

БАТЛАВ

БАТЛАВ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД  
Д.ОЮУНХОРОЛ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД  
С.БЯМБАЦОГТ

## ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### **Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, уул уурхай зэрэг эдийн засгийн салбарын хөгжилтэй уялдан химийн бодисын хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор тэдгээрийн хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл эрчимжих хандлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Химийн хорт болон аюултай бодисын холбогдох эрхзүйн орчинг боловсронгуй болгож, бүртгэл, мэдээллийн цахим санг бий болгох” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд тус яамнаас химийн бодисын хууль, дүрэм журмыг шинэчлэх, сайжруулах талаар зохих ажлуудыг хийж байна.

Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт гарган Засгийн газраар батлуулан мөрдөж байгаа боловч, эдгээр жагсаалтанд ороогүй химийн бодисыг импортлон оруулж ашиглах эрх нээлттэй байгаа нь химийн хорт болон аюулт бодист тавигдах хяналтыг сулруулах магадлалтай юм.

Мөн химийн зарим бодисууд тогтсон нэг нэршилгүй, 3-5, түүнээс ч олон янзаар нэрлэгддэг бөгөөд үүнийг журамласан нэршилийн нэгдсэн тогтолцоо байхгүй байгаа нь одоо ашиглагдаж байгаа болон шинээр нэмэгдэх химийн бодисын бүртгэдэг тогтолцоо байх шаардлагатайг харуулж байна.

Иймээс Монгол Улсад анх оруулж ирж байгаа химийн хорт болон аюултай бодисыг бүртгэдэг, Монгол Улсад ашиглаж болох химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг гарган тушаал шийдвэрээр батлуулж мөрддөг байх шаардлагатай.

Мөн Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяанд химийн бодисыг шинжлэн судлаад зохих дүгнэлт гаргадаг, лабораторийн хүчин чадалтай, мэргэжлийн боловсон хүчинтэй судалгааны нэгж, лаборатори байх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Иймд холбогдох хуулинд нэмэлт оруулж, Монгол улсад ашиглаж болох бодисын жагсаалт гарган, шинээр орж ирэх бодисыг бүртгэлжүүлэх, тодорхой нэг нэршилтэй болгох шаардлага гарч байна.

2013 онд 168 аж ахуйн нэгж байгууллага 302 мянган тн химийн бодис химийн бодис гаднаас импортлон оруулж ирэхээр, холбогдох хууль тогтоомжийн дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсанаас 2013 онд гадаадын хөрөнгө оруулалтай 48 компани 130120,1 тн химийн бодис импортлон ашиглах болон худалдахаар зөвшөөрөл авсан нь тухайн онд нийт зөвшөөрөл авсан химийн бодисын тоо хэмжээний 43% болж байсан.

Ихэнхи гадаадын хөрөнгө оруулалттай ихэнх аж ахуйн нэгж байгууллагууд нь химийн бодис ашиглан уул уурхай, ашигт малтмал, газрын тосны олборлолтыг одоогийн мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахдаа хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд одоо болон цаашид нөлөөлөх нөлөөлийг үл хайхран, өөрсдөдөө ашигтайгаар ашигт малтмалыг бага хугацаанд олборлон авахыг л урьтал болгож байна.

Мөн зарим гадаадын хөрөнгө оруулалттай зарим аж ахуйн нэгж байгууллага нь химийн бодис ил задгай хадгалах, хугацаа нь дууссан болон чанарын шаардлага хангахгүй болсон химийн бодисыг ил хаях, шууд газарт булах, химийн бодисын сав баглаа, боодлыг шатаах зэрэг химийн бодисын хадгалалт, ашиглалттай холбоотой зөрчлийг удаа дараалан гаргаж байсан бөгөөд 2014 оны мэдээллээр, зарим гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагад 500 орчим тонн химийн бодисын хог хаягдал хадгалагдаж байгаа нь аюултай хог хаягдлаа хэрхэн устгах асуудлаа шийдэж чадаагүй манай улсын хувьд маш хүнд асуудал юм.

Мөн сүүлийн үед өндөр хөгжилтэй орнууд байгаль экологийн бохирдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор химийн үйлдвэрээ Ази болон хөгжил дорой бусад тивийн улсууд руу шилжүүлэх, өөрсдийнх нь үйлдвэрлэдэг ижил химийн бодисыг бусад оронд үйлдвэрлэж байвал, үнэ өртөг өндөр ч гаднаас худалдаж авдаг болох хандлага нэмэгдэж байна.

Химийн бодисын импорт, хэрэглээ, ашиглалтанд тавих хяналтыг төр засгаас хүчтэй байлгах ёстой бөгөөд гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хүссэнээр нь химийн бодис импортлон ашиглах, худалдах эрх олгож байгаа нь цаашдаа их хэмжээний химийн бодис ашиглуулан богино хугацаанд ашигт малтмалыг олборлох боломж олгохын зэрэгцээ байгаль орчны доройтол, химийн бодисын бохирдол үүсгэх гэх мэт үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой асуудлуудыг бий болгоно.

Мөн “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тусгагдсан дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудын өсөн дэвжих бололцоог хангах, уул уурхайгаас олох орлогыг бараа ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх замаар ард түмэнд жигд хүртээх зорилгоор химийн хорт болон аюултай бодисын харилцааг зохицуулдаг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулж импортлох, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагааг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гүйцэтгэдэг байх шаардлагатай гэж үзэж байна.

## **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь химийн хорт болон аюултай бодис импортлох, үйлдвэрлэх, худалдах аж ахуйн үйл ажиллагааг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд эрхэлдэг байхаар зохицуулна.

Тус хуулийн төсөл нь 2 зүйлтэй байх бөгөөд 1 дүгээр зүйлд химийн хорт болон аюултай бодис импортлох, үйлдвэрлэх, худалдах аж ахуйн үйл ажиллагааг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд эрхэлдэг байхаар, 2 дугаар зүйлд хууль хэрэгжиж эхлэх хугацааг тус тус тусгана.

## **Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсанаар:

1/Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагуудын уул уурхай, ашигт малтмал, газрын тосны салбар дахь химийн бодис импорт, ашиглалт хязгаарлалттай, зохицуулалттай болно.

2/ Дотоодын аж ахуй нэгж байгууллагуудын өрсөлдөх чадвар, хариуцлага сайжирна.

3/ Дотоодын аж ахуйн нэгж байгууллагаар химийн бодисын импорт, худалдааг гүйцэтгүүлдэг болсноор “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын заалтуудад тусгагдсан түүхий эдийн хавсарга болох, байгаль орчныг доройтуулахаас сэргийлэх, дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах, үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх бололцоогоор хангах гэх мэт үндсэн зарчим хэрэгжихээс гадна дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудын өсөн дэвжих бололцоог хангах, уул уурхайгаас олох орлогыг бараа ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх замаар ард түмэнд жигд хүртээх гэх мэт Монгол улсын язгуур эрх ашиг биелэх боломжтой болно.

## **Дөрөв. Хуулийн төсөл батлагдсанаар цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал**

Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна. Энэ хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор бусад хуульд нэмэлт өөрчлөлт орохгүй.

## **ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд дор дурьдсан агуулгатай дараах хэсгийг нэмсүгэй.

“5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:”

“5.2. Химийн хорт болон аюултай бодис импортлох, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагааг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд эрхэлнэ.”

“6 дугаар зүйлийн 6.1.14 дахь заалт:”

“6.1.14 Монгол Улсад шинээр орж ирэх химийн хорт болон аюултай бодисыг судлах, бүртгэх, ашиглагдаж байгаа химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг гаргаж, бүртгэлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 201.. оны. . . дугаар сарын . . .-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны ... дугаар сарын ...-ны өдрийн хуралдааны ... дугаар тэмдэглэлд:

“I. ХЭЛЭЛЦСЭН нь: Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## Танилцуулга

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, уул уурхай зэрэг эдийн засгийн салбарын хөгжилтэй уялдан химийн бодисын хэрэглээ улам бүр өсөн нэмэгдэж, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Химийн хорт болон аюултай бодисын холбогдох эрхзүйн орчинг боловсронгуй болгож, бүртгэл, мэдээллийн цахим санг бий болгох” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд тус яамнаас химийн бодисын хууль, дүрэм журмыг шинэчлэх, химийн бодис импортлоход төлдөг улсын тэмдэгтийн хураамжийн хязгаарыг өөрчлөх зэрэг ажлуудыг хийж байна.

Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг баталсан байдаг бөгөөд тус жагсаалтанд ороогүй бусад бүх химийн бодисыг импортлон оруулж, ашиглах эрх нь нээлттэй байгаа нь химийн хорт болон аюулт бодист тавигдах хяналтыг сулруулах магадлалтай юм.

Мөн зарим химийн бодисууд 3-5 янзаар нэрлэгддэг, тогтсон нэг нэршилгүй, нэршилийн нэгдсэн тогтолцоо байдаггүй нь одоо ашиглагдаж байгаа болон шинээр нэмэгдэх химийн бодисыг бүртгэдэг тогтолцоотой байх шаардлагатайг харуулж байна.

Иймээс Монгол Улсад анх оруулж ирж байгаа химийн хорт болон аюултай бодисыг бүртгэдэг болох, Монгол Улсад ашиглаж, худалдаж болох химийн хорт болон аюултай бодисын жагсаалтыг гарган тушаал шийдвэрээр батлуулж мөрддөг байх шаардлагатай.

Химийн бодисын орц найрлага, хувь хэмжээ, тухайн бодис мөн эсэхийг нь зайлшгүй лабораторийн шинжилгээгээр л тогтоох шаардлагатай байдаг.

Энэ нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяанд химийн бодисыг шинжлэн судлаад зохих дүгнэлт гаргадаг, лабораторийн хүчин чадалтай, мэргэжлийн боловсон хүчинтэй судалгааны нэгж, лаборатори байх зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Иймд холбогдох хуулинд нэмэлт оруулж, Монгол улсад ашиглаж болох бодисын жагсаалт гаргах, шинээр орж ирэх бодисыг бүртгэлжүүлэх, тодорхой нэг нэршилтэй болгох шаардлага гарч байна.

2013 онд 168 аж ахуйн нэгж байгууллага 302 мянган тн химийн бодис химийн бодис импортлохоор тусгай зөвшөөрөл авсанаас, гадаадын хөрөнгө оруулалтай 48 компани 130120,1 тн химийн бодис импортлон ашиглах болон худалдахаар зөвшөөрөл авсан нь тухайн онд нийт зөвшөөрөл авсан химийн бодисын тоо хэмжээний 43% болж байсан.

Ихэнхи гадаадын хөрөнгө оруулалттай ихэнх аж ахуйн нэгж байгууллагууд нь химийн бодис ашиглан уул уурхай, ашигт малтмал, газрын тосны олборлолтыг одоогийн мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулахдаа хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд одоо болон цаашид нөлөөлөх нөлөөлийг үл хайхран, өөрсдөдөө ашигтайгаар ашигт малтмалыг бага хугацаанд олборлон авахыг л урьтал болгож байна.

Мөн зарим гадаадын хөрөнгө оруулалттай зарим аж ахуйн нэгж байгууллага нь химийн бодис ил задгай хадгалах, хугацаа нь дууссан болон чанарын шаардлага хангахгүй болсон химийн бодисыг ил хаях, шууд газарт булах, химийн бодисын сав баглаа, боодлыг шатаах зэрэг химийн бодисын хадгалалт, ашиглалттай холбоотой зөрчлийг удаа дараалан гаргаж байсан.

2014 оны мэдээллээр, тодорхой зарим гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллагад 500 орчим тонн химийн бодисын хог хаягдал хадгалагдаж байгаа нь аюултай хог хаягдлаа хэрхэн устгах асуудлаа шийдэж чадаагүй манай улсын хувьд маш хүнд асуудал юм.

Мөн сүүлийн үед өндөр хөгжилтэй орнууд байгаль экологийн бохирдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор химийн үйлдвэрээ Ази болон хөгжил дорой бусад тивийн улсууд руу шилжүүлэх, өөрсдийнх нь үйлдвэрлэдэг ижил химийн бодисыг бусад оронд үйлдвэрлэж байвал, үнэ өртөг өндөр ч гаднаас худалдаж авдаг болох хандлага нэмэгдэж байна.

Химийн бодисын импорт, хэрэглээ, ашиглалтанд тавих хяналтыг төр засгаас хүчтэй байлгах ёстой бөгөөд гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хүссэнээр нь химийн бодис импортлон ашиглах, худалдах эрх олгож байгаа нь цаашдаа их хэмжээний химийн бодис ашиглуулан богино хугацаанд ашигт малтмалыг олборлох боломж олгохын зэрэгцээ байгаль орчны доройтол, химийн бодисын бохирдол үүсгэх гэх мэт үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой асуудлуудыг бий болгоно.

Мөн “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д тусгагдсан дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудын өсөн дэвжих бололцоог хангах, уул уурхайгаас олох орлогыг бараа ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх замаар ард түмэнд жигд хүртээх зорилгоор химийн хорт болон аюултай бодисын харилцааг зохицуулдаг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт оруулж импортлох, үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагааг зөвхөн дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гүйцэтгэдэг байх шаардлагатай гэж үзэж байна

Байгаль орчин, аялал жуулчлалын яам